МЭДЭЭ · 2021 оны 7-р сарын 23

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдоос гаргасан 261 гомдол, хүсэлтийг шийдвэрлэлээ



Прокурорын байгууллага энэ сарын 5-9-нд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдоос гаргасан 261 гомдол, хүсэлтийг шийдвэрлэсэн байна.

Тухайлбал, мөрдөгч болон зөрчлийн хэрэг бүртгэх эрх бүхий албан тушаалтанд тодорхой ажиллагаа гүйцэтгүүлэхээр 181 даалгавар бичгээр өгсөн байна. Түүнчлэн мөрдөн байцаалтын 1575 хэрэгт хяналт тавьж, 361 хэрэгт яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлж шийдвэрлэсэн байна